



**ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Ш.Нармандах /МИ-ийн шинжээч/

2020.09.29

1.Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1.Жирэмсэн эхийг жирэмсний эхний

3 сарын дотор
хяналтанд
хамруулсан хувь
өмнөх оноос
нэмэгдсэн байх

- Холбогдох стандарт, удирдамж, журам зааврын дагуу жирэмсэн эхийг хяналтанд хамруулах
- Жирэмсэн болон төрсний дараа үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам ЭМ-ийн сайдын 2019 оны 318 дугаар тушаал
- “Эхээс хүүхдэд ХДХВ,гепатитийн В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох журам” ЭМ-ийн сайдын 2019 оны А/614 дүгээр тушаал
- ӨЭМТ-ийн бүтэц үйл ажиллагаагы стандарт MNS5292:2017 хэрэгжүүлэн ажиллана.
- Статистик үзүүлэлтэд үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан дунджаас өндөр үзүүлэлтийг сайжруулах арга хэмжээ авсан байна.

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.2.Эрсдэлтэй жирэмснийг илрүүлж, хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх

2.3.Хүндрэлтэй төрсөн эх, нярайн судалгаатай байх, гэрийн эргэлт, хяналтыг тогтмол хийдэг байх

3.1.Төрсний дараа эх, нярайд тавих хяналтыг стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх

- Судалгаатай, үр дүнг тооцон ажилласан байх
- Эрсдэлтэй жирэмсэнг илрүүлэх асуумжийг үнэн зөв, хяхуур хийж, эрсдэлийн бүлгийг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.
- Бүртгэлийг бүрэн гүйцэд хийх
- Төрсний дараах гэрийн эргэлтийг удирдамжид заасны дагуу хийж, тогтмолжуулсан, авсан арга хэмжээг цаг хугацаанд нь баримтжуулсан байх
- Нярайн өсөлт, хөгжлийн тоон болон чанарын үзүүлэлтэд үнэлгээ өгсөн байх




2.Хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1.Хүүхдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийдэг, насны бүлгээр хянах графиктай, мөрддөг байх

2.2.Нэг хүртэлх насны хүүхдийг гэрийн идэвхтэй эргэлтээр үзэж тусламж, үйлчилгээ үзүүлсэн байх



- Бүтэц үйл ажиллагааны стандартад зааснаар тав хүртэлх насны хүүхдийг үзлэгт бүрэн хамруулсан, эрүүл мэндийг хяналтыг графикын дагуу хийсэн, бүртгэлийг хөтөлсөн байх.
- Эх, хүүхдийн дэвтрийг бүрэн хөтөлсөн байх
- Эх хүүхдийн талаарх эрүүл мэндийн мэдээллийг сайжруулсан байх
- Олон найрлагатай бичил тэжээл хэрэглэсэн 6-23 сартай хүүхдийн өсөлтөд судалгаа, дүгнэлт өгч ажилласан байх



3. Зорилтот бүлгийн үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээг удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх

1.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээг удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу үзүүлдэг байна.

- Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүртгэл, судалгааг гаргаж, шинэчилсэн байх
- Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хяналтад авсан, гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлсэн тухайгаа бүртгэн тэмдэглэсэн байх.
- “Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх журам” ЭМ-ийн сайдын 2017 оны А/41 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах



4.Халдварт бус өвчний тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан халдварт бус өвчний багц бүрээр хүн амд тусламж үзүүлдэг байх

- “ӨЭМТ-д үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлах тухай”
- ЭМ-ийн сайдын 2017 оны А/129 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах, түүнд үнэлгээ өгсөн байх
- Холбогдох анхан шатны маягтыг бүрэн хөтөлсөн байх

5.Халдварт өвчний үеийн тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.Өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан халдварт өвчний үзлэг, оношилгоо, эмчилгээ, хяналтыг стандарт удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг байх

- Үзүүлсэн тусламж үйлчилгээний үр дүнг тооцсон байх
- Эргэн мэдээлэл, хяналтыг сайжруулсан байх
- Холбогдох анхан шатны маягтыг бүрэн хөтөлсөн байх

6. Уламжлалт анагаах ухааны болон сэргээн засах тусламж, үйлчилгээ:

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан төрлөөр уламжлалт анагаах ухааны тусламжийг үзүүлдэг байх

1.2. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх

- Мэргэжилтэнтэй байх
- Стандарт, удирдамжтай байх
- Тусламж үйлчилгээний жагсаалтыг гарган баталгаажуулсан байх
- Тусламж үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлсэн, багаж, хэрэгсэл, аппаратаар хангасан байх
- Үзүүлж байгаа тусламж үйлчилгээнийг үр дүнг тооцсон судалгаатай байх
- Анхан шатны маягтын хөтлөлтийг бүрэн хөтөлсөн байх



ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.3.Тусламж,
үйлчилгээний
жагсаалтад заасан
төрлөөр сэргээн засах
тусламж үйлчилгээ
үзүүлдэг байх

- Мэргэжилтэнтэй байх
- Стандарт, удирдамжтай байх
- Тусламж үйлчилгээний жагсаалтыг гарган баталгаажуулсан байх
- Тусламж үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлсэн, сэргээн засах эмчилгээ хийх багаж, тоног төхөөрөмжөөр хангасан байх
- Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн бүртгэл хөтлөх
- Үзүүлж байгаа тусламж үйлчилгээнийг үр дүнг тооцсон судалгаатай байх
- Анхан шатны маягтын хөтлөлтийг бүрэн хөтөлсөн байх

7. Сувилахуйн тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.2.Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээний жагсаалтын дагуу тусламж үзүүлдэг байх

2.5.Жирэмсэн болон төрсөн эх, нярайд сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгдөг байх



- Тусламж үйлчилгээний жагсаалтад заасан тусламж үзүүлсэн бүртгэлийг бүрэн хөтлөх
- Мэдээ, тайланд үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан байх
- АШМ-ын хөтлөлтийг тогтмолжуулсан байх
- Зөвлөгөө өгсөн бүртгэлтэй байх
- Гарын авлагатай байх

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.6.Тусламж,
үйлчилгээний жагсаалтад
заасан сувилахуйн
тусламж, үйлчилгээний
гардан үйлдлийг хийх
эмнэлгийн мэргэжилтний
ур чадварыг үнэлдэг,
сургадаг байх

- Эрүүл мэндийн технологи,
оношилгоо, эмчилгээний
түгээмэл үйлдлүүд
MNS4621:2008 стандарт,
холбогдох журмын
хэрэгжилтэд хяналтын
хуудсаар үнэлгээ хийсэн,
хяналтын мөрөөр арга
хэмжээ авсан байх
- Зохион байгуулсан сургалт,
дадлагыг баримтжуулсан
байх

8.Яаралтай тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.2.Яаралтай тусламжийн үеийн эрэмбэлэн ангилалтыг хийх удирдамж, эмнэлзүйн зааврыг мөрддөг байх

3.1.Амилуулах тусламжийг үзүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж, дадлагажуулдаг байх

4.1.Яаралтай тусламжийн багаж, тоног төхөөрөмжөөр хангасан, хэвийн болон аюулгүй ажиллагааг хангасан байх

- ЭМ-ийн сайдын 2019 оны А/293 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллах
- Удирдамж, гарын авлагаар хангах
- Эмнэлгийн мэргэжилтнүүдэд бататгах, сэргээх сургалтыг тогтмолжуулах, үр дүнг тооцох
- Тушаалд заасны дагуу багаж, тоног төхөөрөмжийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, зөв хадгалах
- Яаралтай тусламжийн багаж, тоног төхөөрөмж, ЭМ, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдалд шалгах хуудас ашигладаг болох

9.Тусламж, үйлчилгээний ажилбар, гардан үйлдлийг хийх

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.Тусламж,
үйлчилгээний
жагсаалтад заасан
гардан үйлдлийг
стандарт, удирдамж,
эмнэлзүйн зааврын
дагуу хийдэг байх

1.2.Тусламж,
үйлчилгээний жагсаалтад
заасан гардан үйлдлийг
хийх эмнэлгийн
мэргэжилтний ур
чадварыг үнэлдэг,
сургадаг байх

- Түгээмэл үйлдлийн жагсаалтыг гарган батлах
- Стандарт, удирдамжийн мөрдөлтөд тавих хяналт, үнэлгээг тогтмолжуулах
- Хяналтын хуудсыг боловсруулан ашиглах
- Эмнэлгийн мэргэжилтний ур чадварт үнэлгээ өгөх, сургалт, дадлагыг чанартай зохион байгуулах, үр дүнг тооцох
- Сургалтад муляж ашиглах

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

3.2.Өвчтөнд хэрэглэх эм, тарианы үйлчлэл, хэрэглэх аргыг тайлбарлаж, зөвлөгөө өгдөг байх

3.3.Өвчтөнд хийсэн эм, тарианы тэмдэглэгээг хөтөлдөг байх

3.5.Ижил дуудагддаг, гадна байдал нь ижил харагддаг эмүүдийн жагсаалттай байх

5.1.Эмийн жорыг стандартын дагуу бичдэг байх

- MNS 4621:2008 “Эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний түгээмэл үйлдлүүд”
- MNS 5530:2014 Эрүүл мэндийн технологи “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага”
- MNS 5376:2014 “Эмийн жорын маягт, жор бичилт” стандартуудыг мөрдөх
- Эм, тариа хийсэн бүртгэлийг хөтлөхдөө **цаг хугацаа, гаж нөлөө** илэрсэн үгүйг тэмдэглэх
- Ижил дуудагддаг, ижил төстэй харагддаг эмүүдийн жагсаалтыг гарган эрсдэл, аюулгүй байдлыг ханган ажилладаг байх /өнгөөр кодлох, нэмэлт анхааруулга наах, нэг дор байрлуулахгүй байх гэх мэт/
- Эмийн жорыг стандартын дагуу бичих

12.Лабораторийн тусламж, үйлчилгээ

ШАЛГУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1.Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан оношилгоо, шинжилгээг хийдэг байх

- Лабораторийн шинжилгээ хийх жагсаалтыг гаргаж, баталсан байх
- Оношлуур, тестийн нөөцийг бүрдүүлсэн, үйлдвэрлэгчийн зааврын дагуу зөв хадгалсан байх
- АШМ-ын хөтлөлтийг бүрэн хөтөлсөн байх

Анхаарах асуудал:

1. Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд хамт олны оролцоог ханган ажиллах
2. Магадлан итгэмжлэх шалгуурын өөрийн үнэлгээг бодитой хийх
3. ЭМ-ийн бүртгэлийн маягтуудын хөтлөлтийг тогтмолжуулах
4. Төвд ажиллаж байгаа баг, хорооны уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах
5. Холбогдох эрх зүйн актуудыг судлан, хэрэгжилтэд үнэлгээ өгч ажиллах
6. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага менежментийн сургалтыг зохион байгуулах, үр дүнг тооцох
7. Үзүүлж байгаа тусламж үйлчилгээний үр дүнг тооцсон судалгаатай ажиллах
8. Тусламж үйлчилгээний чанарт ахиц гарган ажиллах
9. Статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх
10. Дотоод хяналтыг тогтмолжуулах, хяналтын мөрөөр авах арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.